

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ”

Хаалттай хувьцаат компани

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

	Хуудасны №
Санхүүгийн тайланд хүлээх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл	2
Байгууллагын талаарх мэдээлэл	3-4
Хараат Бус Аудиторын тайлан	5-8
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангууд	9-14
Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	9
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан	10-11
Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан	12-13
Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	14
Санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд	15-78
Тайлагнагч аж ахуйн нэгж	15-17
Тайлан бэлтгэсэн үндэслэл	18
Тайлан Нэгтгэсэн үндэслэл	19
Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл	20-21
Санхүүгийн хэрэгслүүд –Эрсдэлийн Удирдлага	22-30
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	31-51
Холбоотой талын тодруулга	52-53
Сегментийн мэдээлэл	54-57
Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй	58-69
Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандарт, тайлбар ба нэмэлт өөрчлөлтүүд	70-77
Болзошгүй өр төлбөр	76
Санхүүгийн Тайлангийн нэмэлт тодруулгууд	77

**2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 5-8 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК (“АСН” гэх) болон “АСН”-ийн хяналттай охин компаниуд болох “Ард Секюритиз ҮЦК” ХХК, “Тэнгэр системс” ХХК, “МТНД” ХХК, “Ард Даатгал” ХХК, “Ард Кредит ББСБ” ХХК, “Ард Менежмент” ХХК, “Жинст-Увс” ХК, “Алтан Хоромсог ҮЦК” ХХК, “Ард Лайф” ХХК-ийг багтаасан групп (“Групп” гэх)-ын 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Группийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Ард Санхүүгийн Нэгдэл” группийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

Ч.ГАНХУЯГ

Гүйцэтгэх захирал

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

*Ерөнхий нягтлан
бодогч*

Улаанбаатар хот, Монгол улс

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК
Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 2005 оны 10 сарын 10-ны өдрийн үүсгэн байгуулагчдын шийдвэрийн дагуу “И Ай Ти” ХХК нэртэйгээр Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр анх үүсгэн байгуулагдсан.
 2014 оны 04 сарын 08-ний өдрийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу “И Ай Ти” ХХК-ийн нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” болгон өөрчилсөн бөгөөд 2014 оны 06 сарын 26-ны өдрөөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлсэн.
 Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 12-р сарын 03-ны өдрийн шийдвэрийн дагуу Хаалттай Хувьцаат Компани болох шийдвэр гаргасан бөгөөд 2015 оны 11 сарын 23 –ны өдрөөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар бүртгүүлсэн.

Нэгтгэгдсэн компаниуд	2016 он			2015 он
	“Ард Секюритиз УЦК” ХХК	100%	Тийм	Тийм
	“Тэнгэр Системс” ХХК	100%	Тийм	Тийм
	“МТНД” ХХК	100%	Тийм	Тийм
	“Ард Даатгал” ХХК	83.03%	Тийм	Тийм
	“Ард Кредит ББСБ” ХХК	80.7%	Тийм	Тийм
	“Ард Менежмент” ХХК	100%	Тийм	Тийм
	“Жинст-Увс” ХК	84.6%	Тийм	Тийм
	“Алтан Хоромсог УЦК” ХХК	100%	Тийм	Үгүй
	“Ард Лайф” ХХК	100%	Тийм	Үгүй

Гол хувь нийлүүлэгчид	2016 он			2015 он
	Хишигдорж Батхишиг			12%
	Луна Энд Луна ХХК			10.3%
	Венчурс Уан			9.26%
	Бруно Рашле			9.25%
	Чулуун Ганхуяг			8.04%
	Хөрөнгө Оруулагч Үндэстэн ХК			7.5%
	Интергрупп Интернэйшнл ХХК			6.51%
	МАК ХХК			6.2%
	Сэдбазар Гэрэлтуяа			3.21%
	Бусад			27.72%
				100%

Төлөөлөн Удирдах Зөвлөл	2016 он			2015 он
	ТУЗ-ийн дарга			Ж.Оюунгэрэл
	ТУЗ-ийн гишүүд			Ч.Ганхуяг
				О.Одбаяр
				Ц.Ариунтөгс
				Л.Соронзонболд
				Бруно Рашле
				В.Баяржаргал
				П.Батбаяр
				Г.Цогбадрах
				Энтони Хоброу

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК
Байгууллагын талаарх мэдээлэл

Гүйцэтгэх Удирдлага	Гүйцэтгэх захирал	Ч.Ганхуяг
Байнгын хаяг	Ард Санхүүгийн Нэгдэл ХК Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг , 8-р хороо, Өнгөт хэвлэл ХХК-ийн байр, 2 давхарт	
Аудитор	БДО Аудит ХХК Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам-62, ЮНЕСКО-ын гудамж, Юнион Бюлдинг, “Б” блок, 15-р давхар, 1502 тоот	

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Санал дүгнэлт

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болон түүний охин компаниудыг багтаасан группийн (‘Групп’ гэх) дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2016 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөрх жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийг томоохон бодлогуудын хураангуйг агуулсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласнаас бусад бүх материаллаг талаараа хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь группийн 2016 оны 12 сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Компани 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнөх хугацаанд худалдан авч нэгтгэсэн хараат болон охин компаниудын худалдан авалтыг *СТОУС 3, Бизнесийн нэгдэл* –д заасны дагуу тодорхойлогдох хөрөнгө, хүлээж болох өр төлбөр, цөөнхийн оролцоо зэргийн бодит үнэ цэнийг олж эзэмшсэн өдрөөр хэмжиж, гүүдвилийг тооцоолоогүй, хөрөнгө өр төлбөрийн дансны үнэд суурилан гүүдвилийг тооцоолсон байна. Бид аудитын явцад эдгээр нэгдлүүдийн өдрөөрх гүүдвилийг үнэн зөв тооцоолох боломжгүй байсан.

Мөн Тэмдэглэл 21, Гүүдвил-д тусгагдсан 5,488,568 мянган төгрөг (2014: 5,128,272 мян.төг)-ийн гүүдвилд тайлант жилийн эцсээр аливаа үнэ цэнийн бууралтад орсон эсэх талаар тест хийж баримтжуулаагүй бөгөөд аудиторудыг гүүдвилийн үнэ цэнэ буураагүй гэсэн зохистой бөгөөд хангалттай нотолгоогоор хангаагүй.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (‘НБЁЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт бид найдаж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их нөлөөтэй байсан асуудлууд байдаг. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан хийсэн өөрсдийн аудитын ажил болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар гаргах дүгнэлтийн хэлбэрийг тодорхойлохын аль алинд нь эдгээр асуудалд анхаарсан бөгөөд гэхдээ бид эдгээр асуудлуудын талаар тусад нь санал дүгнэлт гаргадаггүй.

АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

АУДИТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

1 Материаллаг дүн бүхий мөнгөн бус ажил гүйлгээ

Групп 2016 онд нэг компанид оруулсан хөрөнгө оруулалтаа компанийн дөрвөн хувьцаа эзэмшигчдэд худалдсан. Энэхүү арилжааны үнийн нэг хэсэг нь тухайн хувьцаа эзэмшигч нарын эзэмшиж байсан Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны солилцоогоор хийгдэж, үлдсэн хэсэг нь санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгийн солилцоогоор хэрэгжсэн.

Энэхүү бартерын арилжааны төлбөрт хүлээн авсан биет хөрөнгө болон санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь хэлцлийн үнээр тодорхойлогдсон учраас бид өөрсдийн мэргэжлийн шийдэлд үндэслэн энэхүү хэлцлийг аудитын гол асуудалд оруулсан

Хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэл 43-ээс харна уу.

Материаллаг дүн бүхий мөнгөн бус ажил гүйлгээтэй холбоотойгоор бид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хэлцэлд оролцогч худалдагч болон худалдан авагч талууд худалдаж байгаа болон худалдан авч байгаа зүйлсийн үнэ цэнийг бодитой тодорхойлсон эсэхийг лавласан.
- Мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан барааны солилцсон үнэ нь ижил төрлийн хөрөнгийн зах зээлийн дундаж үнэтэй ойролцоо эсэхийг шинжилсэн.
- Хөрөнгийн төлбөрт гаргасан санхүүгийн хэрэгсэл нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн эсэхийг шинжилсэн.
- Худалдан авагч болон худалдагч талуудын энэхүү арилжааг хийхэд хүргэсэн дарамт шахалт байгаагүй эсэхийг магадалсан.

Эцэст нь бид дээрх ажил гүйлгээ холбогдох нотолгоогоор хангагдаж байна гэж үзсэн.

АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

АУДИТЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

2 Даатгалын нөөц сангийн тооцоолол

Ердийн даатгалын нөөц санг гэдэгт доорх нөөц сангууд багтана.

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) гэдэгт тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.

Орлогот тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН) гэдэгт даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсгийг ойлгоно.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС) гэдэгт даатгалын тохиолдол болсон тухай даатгагч мэдсэн болон төлөөгүй байгаа нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнг ойлгоно.

Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХБТБНС) гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.

Группийн охин компани болох Ард даатгал компани нь СЗХ –оос батлагдсан шинэ журмыг хэрэгжүүлж 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нийт 4,355,185 мянган төгрөгийн нөөц сантай байна. Даатгалын нөөц сангийн тооцоолол нь мэргэжлийн актуар тооцоолол ашиглахыг шаарддаг учир тооцоолол болон хэмжилтэд алдаа гарах эрсдэл байна гэж үзсэн.

Бид нөөцийн сангийн тооцоолол болон хүлээн зөвшөөрөлтийг хамрах голлох дотоод хяналтын тогтолцоо, процессыг үнэлж шалгасан. Мөн бид аудитын ажилдаа хөндлөнгийн хараат бус, хангалттай үр чадвар бүхий аудиторын экспертийн ажлыг ашиглан даатгалын нөөц сангийн тооцооллыг шалгуулсан. Манай хөндлөнгийн актуарын эксперт нь нөөцийн сангийн тооцоололд ашигласан өгөгдлүүдийн үл үндэслэлтэй байдал, арифметик тооцоолол үнэн зөв эсэхийг шинжилжээ, дахин тооцоолол болон зарим биет горимуудыг гүйцэтгэн шалгасан.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан багтаагүй байж болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан, аудитын үед олж авсан бидний ойлголт, мэдлэгээс өөрөөр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн аудитын ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд Удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, алдаа юмуу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь Группийг татан буулгах юмуу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголтгүй байхаас бусад тохиолдолд өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх Группийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Төлөөлөн удирдах зөвлөл нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа бүх материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлнэ гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс юм уу алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа юмуу нийлбэрээрээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичигийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухай нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл

байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Д.Алтансүх
БДО Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО гудамж, Нарны зам-62
ЮНИОН Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: _____

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тэм	2016 он мян.төг	2015 он мян.төг
Борлуулалтын орлого – цэвэр	6	19,324,115	19,446,549
Борлуулалтын өртөг	7	(5,573,443)	(5,651,257)
Нийт ашиг		13,750,672	13,795,292
Цалин хөлс, түүнтэй адилтгах зардал	8	(2,576,487)	(1,880,726)
Ерөнхий удирдлагын зардал	9	(3,399,495)	(3,552,032)
Үйл ажиллагааны ашиг		7,774,690	8,362,534
Санхүүгийн орлого/(зардал)	10	1,616,952	968,341
Борлуулах зорилготой санхүүгийн хөрөнгийн үнэлгээний олз/гарз		1,376	(75)
Хараат компанийн цэвэр ашгийн ногдох хувь	11	394,126	187,263
Бусад орлого/(зардал)	12	(43,731)	238,321
Бусад олз/(гарз)	13	(335,752)	(172,228)
Татвар төлөхийн өмнөх ашиг		9,407,661	9,584,156
Орлогын татварын зардал	14	(230,000)	(166,381)
Хэвийн үйл ажиллагаанаас олсон ашиг		9,177,661	9,417,775
Зогсоосон үйл ажиллагаанаас олсон ашиг	15	-	9,802
Тайлант жилийн цэвэр ашиг		9,177,661	9,427,577
Хяналтын бус хувь оролцооны зардал	16	(136,916)	(59,444)
Группийн цэвэр ашиг		9,040,745	9,368,133
Нэгж хувьцаанд ногдох ашиг- Төгрөг	17	658	555

13-77 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэм	2016 оны 12-р сарын 31 мян.төг	2015 оны 12-р сарын 31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бүс хөрөнгө			
Өмч, барилга, тоног төхөөрөмж - цэвэр	18	1,365,479	2,738,772
Биет бүс хөрөнгө - цэвэр	19	52,416	44,109
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	20	1,894,933	675,148
Гүүдвил	21	5,488,569	5,128,272
Урт-хугацаат зээлийн авлага	22	5,038,698	1,496,985
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө	23	821,781	-
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	25	1,230,413	1,115,914
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	26	7,925,538	2,531,446
Нийт эргэлтийн бүс хөрөнгө		23,817,827	13,730,646
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	24	3,097,600	-
		26,915,427	13,730,646
Эргэлтийн хөрөнгө			
Бусад эргэлтийн хөрөнгө			
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	27	829,867	621,702
Бараа материал	28	64,329	31,111
Богино-хугацаат зээлийн авлага	29	4,378,686	4,296,316
Худалдааны болон бусад авлага	30	2,397,641	9,254,892
Бусад богино-хугацаат санхүүгийн хөрөнгө	31	1,005,045	146,872
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	43	3,610,491	7,485,551
Нийт эргэлтийн хөрөнгө		12,286,059	21,836,444
НИЙТ ХӨРӨНГӨ		39,201,486	35,567,090

13-77 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

	Тэм	2016 оны 12-р сарын 31 мян.төг	2015 оны 12-р сарын 31 мян.төг
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Хувьцаат капитал	32	1,879,653	1,879,653
Нэмж төлөгдсөн капитал - Энгийн хувьцаа	33	10,400,013	10,400,013
Халаасны хувьцаа	32	(471,579)	(522,791)
Нэмж төлөгдсөн капитал - Халаасны хувьцаа		(6,144,347)	(5,547,966)
Өмчийн бусад хэсэг	34	13,799	13,799
Хуримтлагдсан ашиг, алдагдал		22,672,884	13,658,043
Хяналтын бус хувь оролцоо	35	1,058,351	2,489,496
Нийт өмч		29,408,774	22,370,247
Өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр			
Урт-хугацаат зээл	36	200,000	429,343
Санхүүгийн түрээсийн өглөг	37	110,127	-
Хойшлогдсон татварын өр	38	56,038	3,467
Урт хугацаат өр төлбөр		366,165	432,810
Богино хугацаат өр төлбөр			
Худалдааны болон бусад өглөг	39	3,758,688	7,644,738
Эрсдэлийн нөөц	40	1,343,182	1,370,658
Орлогын татварын өглөг		97,083	86,700
Урт хугацаат санхүүгийн түрээсийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	37	31,326	-
Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	36	20,406	11,976
Богино-хугацаат зээл	41	1,154,501	486,564
Урьдчилж орсон орлого	42	3,021,361	3,163,397
Нийт богино хугацаат өр төлбөр		9,426,547	12,764,033
Нийт өр төлбөр		9,792,712	13,196,843
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		39,201,486	35,567,090

13-77 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2016 он мян.төг	2015 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	9,407,661	9,584,156
<i>Тохируулга:</i>		
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл	224,386	248,190
Биет бус хөрөнгийн хорогдуулга	-	11,060
БҮТЭЗ-ийн хорогдуулга	13,455	2,476
Хараат компанийн (ашиг)/алдагдлын ногдох хэсэг	(394,126)	(187,263)
Эрсдэлийн нөөцийн зардал	131,478	69,400
Найдваргүй авлагын зардал	3,099	71,666
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз/(олз)	264,641	126,373
Бараа материал данснаас хассан гарз/(олз)	-	7,844
Хараат компани худалдсаны гарз/(олз)	(7,205,197)	-
Зогсоосон үйл ажиллагааны ашиг	-	9,802
Хөрөнгө оруулалт данснаас хассаны гарз/(олз)	-	10,000
Охин компанийн худалдан авалтын үеийн олз	-	(38,415)
Ханшийн зөрүүгийн гарз/(олз)	(593,300)	-
Ногдол ашгийн орлого	-	(50,002)
Хүүгийн орлого	(1,610,034)	(2,032,460)
Хүүгийн зардал	113,239	369,540
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	355,302	8,202,367
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>		
Бусад эргэлтийн хөрөнгийн бүүралт/(өсөлт)	-	(3,096)
Урьдчилж төлсөн зардал, тооцооны бүүралт/(өсөлт)	(212,516)	46,535
Бараа материалын бүүралт/(өсөлт)	(33,218)	(5,283)
Зээлийн авлагын бүүралт/(өсөлт)	2,185,177	(2,994,176)
Худалдааны болон бусад авлагын бүүралт/(өсөлт)	6,897,623	(6,515,603)
Худалдааны болон бусад өглөг өсөлт/(бүүралт)	(7,355,597)	6,675,721
Эрсдэлийн нөөцийн өсөлт/(бүүралт)	(27,474)	(207,714)
Урьдчилж орсон орлогын өсөлт/(бүүралт)	(142,037)	651,155
Бусад эргэлтийн өр төлбөрийн өсөлт/(бүүралт)	(34)	(137,313)
Үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн гүйлгээ	1,667,226	5,712,593
Төлсөн орлогын татвар	(167,012)	(391,249)
Хүүгийн төлөлт	(164,643)	(339,174)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,335,571	4,982,170

13-77 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (үргэлжлэл)

	2016 он мян.төг	2015 он мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	(1,046,023)	(2,341,871)
Худалдсан борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	146,872	1,740,211
Бусдад олгосон зээл	(3,269,258)	-
Бусдад олгосон зээлийн эргэн төлөлт	907,329	-
Худалдан авсан өмчийн хөрөнгө оруулалт	(4,939,420)	(139,466)
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(360,296)	(126,098)
Худалдсан өмч, барилга, тоног төхөөрөмж	555,848	373,973
Худалдаж авсан биет бус хөрөнгө	(17,411)	(100)
Худалдаж авсан дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт	(771,991)	-
Хүлээн авсан ногдол ашгийн орлого	-	50,002
Хүлээн авсан хүүгийн орлого	1,575,978	1,987,240
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(7,218,372)	1,543,891
САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Эргэлтэд гаргасан хувьцаа	3,083,009	1,218,864
Худалдаж авсан халаасны хувьцаа	-	(5,944,247)
Хяналтын бус хувь оролцоо	(1,568,060)	(254,923)
Авсан зээл	1,740,650	715,653
Зээлийн төлөлт	(1,247,858)	(717,059)
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,007,741	(4,981,712)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,875,060)	1,544,349
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	43 7,485,551	5,941,202
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43 3,610,491	7,485,551

13-77 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал - Энгийн хувьцаа	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал - Халаасны хувьцаа	Хуримтлагдсан ашиг	Өмчийн бусад хэрэглүүр	Группэд хамаарах өмчийн дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт өмч
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
	32	33	32			34		35	
2015 оны 1 сарын 1-ээр	1,833,551	9,257,629	(156,887)	-	4,202,566	13,799	15,150,659	2,684,975	17,835,634
Хувьцаа халаасалсан	-	-	(396,283)	(5,547,966)	-	-	(5,944,249)	-	(5,944,249)
ЭЗИТБ-ын нөлөө	-	-	-	-	87,344	-	87,344	-	87,344
Эргэлтэд гаргасан халаасны хувьцаа	46,102	1,142,384	30,379	-	-	-	1,218,864	-	1,218,864
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	-	-	-	-	-	(109,286)	(109,286)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	(145,637)	(145,637)
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	9,368,133	-	9,368,133	59,444	9,427,577
2015 оны 12 сарын 31-ээр	1,879,653	10,400,013	(522,791)	(5,547,966)	13,658,043	13,799	19,880,751	2,489,496	22,370,247
Хувьцаа халаасалсан	-	-	(311,363)	(5,673,395)	-	-	(5,984,758)	-	(5,984,758)
Тайлант оны алдаа	-	-	-	-	(25,904)	-	(25,904)	-	(25,904)
Бизнесийн нэгдлээр нэмэгдсэн	-	-	-	-	-	-	-	(1,568,061)	(1,568,061)
Эргэлтэд гаргасан халаасны хувьцаа	-	-	362,575	5,077,014	-	-	5,439,589	-	5,439,589
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	9,040,745	-	9,040,745	136,916	9,177,661
2016 оны 12 сарын 31-ээр	1,879,653	10,400,013	(471,579)	(6,144,347)	22,672,884	13,799	28,350,423	1,058,351	29,408,774

13-77 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь 2005 оны 10 сарын 10-ны өдрийн үүсгэн байгуулагчдын шийдвэрийн дагуу “И Ай Ти” ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2005 оны 10 сарын 18-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж Улсын Бүртгэлийн 9011036140 тоот дугаар бүхий, 5024145 тоот регистрийн дугаартай гэрчилгээг авсан.

2014 оны 04 сарын 08-ний өдрийн ТУЗ-н шийдвэрийн дагуу “И Ай Ти” ХХК-ийн нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХХК болгон өөрчилсөн бөгөөд 2014 оны 06 сарын 26-ны өдрөөр улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 12 сарын 03-ны өдрийн шийдвэрийн дагуу Хаалттай Хувьцаат Компани болох шийдвэр гаргасан бөгөөд 2015 оны 11 сарын 23 –ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар бүртгүүлсэн.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалт ба бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ юм.

“Тэнгэр Системс” ХХК нь 2007 оны 07 сарын 16-ны өдөр компанийн дүрмийн дагуу Монгол улсын хуулийн этгээд болох Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр байгуулагдсан бөгөөд 2007 оны 07 сарын 16-ны өдөр програм хангамж боловсруулах чиглэлээр 9011108150 тоот улсын бүртгэлийн дугаартай, 5151716 регистрийн дугаар бүхий Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК, түүний охин компаниуд болон гуравдагч талуудад програм хангамж боловсруулж өгөх, програм хангамж худалдах болон програм хангамжтай холбоотой бусад үйлчилгээг үзүүлдэг.

“Ард секюритиз ҮЦК” ХХК нь анх 1997 онд “БАТС инвест” ХХК нэрээр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах 2111063 регистрийн дугаар бүхий 24/987 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ аван үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

“БАТС инвест” ХХК-ийн нэрийг 2009 оны 12-р сарын 11-ний өдөр “Монет” ХХК болгон, “Монет” ХХК-ийн нэрийг 2012 оны 2 дугаар сарын 14-ний өдөр “Монеткапитал” ХХК болгон, “Монеткапитал” ХХК-ийн нэрийг 2014 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр “Монеткапитал ҮЦК” ХХК, “Монеткапитал ҮЦК” ХХК-ийн нэрийг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр “Ард секюритиз ҮЦК” ХХК болгон тус тус өөрчилсөн.

Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн болон андеррайтерын үйл ажиллагаа эрхэлдэг.

“МТНД” ХХК нь 2010 оны 05-р сарын 27-ны өдөр бизнесийн зөвлөх чиглэлээр 9011232100 тоот улсын бүртгэлийн дугаартай, 5382645 регистрийн дугаар бүхий Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан. Санхүүгийн мэдээлэл, санхүүгийн зөвлөгөө, санхүүгийн сургалт, бизнесийн зөвлөх зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ (үргэлжлэл)

“Ард Даатгал” ХХК нь анх 1994 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн үүсгэн байгуулагчдын 01 тоот шийдвэрийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр үүсгэн байгуулагдсан.

Компани Улаанбаатар хотын дүүргүүд, 21 аймагт салбартайгаар ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд даатгалын үйл ажиллагаа эрхлэх 2/16 тоот тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ердийн даатгалын 15 хэлбэрийн үйлчилгээг үзүүлж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Ард Даатгал ХХК-ийн 33 хувийг 2013 оны 12 сард, 22.31 хувийг 2014 оны 12-р сард, 2016 оны 5 сард 11.27 хувийг, 2016 оны 09 сард нэмж 16.72 хувийг худалдан авч нийт 83.03 хувийг эзэмшиж байгаа бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2014 оноос нэгтгэсэн санхүүгийн тайланд хамруулсан.

“Ард Кредит ББСБ” ХХК нь анх 2011 оны 04-р сарын 21-ний өдөр үүсгэн байгуулагдсан ба 2011 оны 04 сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор Банк Бус Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/222 тоот гэрчилгээ авсан. 2011 оны 04 сарын 22-ны өдөр Зээлийн үйл ажиллагаа, Гадаад валютын арилжаа, Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэхээр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 5459567 регистрийн дугаар бүхий 9015002031 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Ард Кредит ББСБ ХХК-ийн 50 хувийг 2013 оны 12-р сард, 2015 оны 5 сард 8 хувийг, 2016 оны 12 сард 22.7 хувийг худалдан авч нийт 80.7 хувийг эзэмшиж байгаа бөгөөд 2014 оноос Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хамруулсан.

“Ард Менежмент” ХХК нь анх 2011 оны 09 сарын 06-ний өдөр Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан ба 2011 оны 09-р сарын 06-ны өдөр Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 5510759 регистрийн дугаар бүхий 9011306066 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан. 2014 оны 12-р сарын 03-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор хувийн хөрөнгө оруулалтын санг удирдах зорилгоор компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулахаар шийдвэр гаргасан. Үүнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүссэн материалаа бүрдүүлэн өгсөн байгаа болно.

“Жинст-Увс” ХК нь 1996 оны 04-р сарын 20-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 01 тоот тогтоолоор Хувьцаат Компанийн хэлбэрээр анх үүсгэн байгуулагдсан. 2007 оны 01 сарын 30-ны өдөр Улсын Бүртгэлийн Албанд шинэчлэн бүртгүүлж 2001861 регистрийн дугаар бүхий 1510001010 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

“Жинст-Увс” ХК-ний үндсэн үйл ажиллагаа нь Үр тариа болон бусад ургамал тариалалт, таван хошуу мал, цаа буга, сүүний фермийн үйл ажиллагаа, бусад түүхий эд, хоёрдогч түүхий эдийн бөөний худалдаа эрхлэх гэж улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгдсэн байгаа ч тайлант жилийн эцсээр идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байна.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ (үргэлжлэл)

“Алтан Хоромсог ҮЦК” ХХК нь 1996 оны 02-р сарын 02-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 01 тоот тогтоолоор Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр анх үүсгэн байгуулагдсан. 2007 оны 11 сарын 09-ны өдөр Улсын Бүртгэлийн Албанд шинэчлэн бүртгүүлж 2030055 регистрийн дугаар бүхий 9011124089 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

Алтан Хоромсог ҮЦК ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь брокер, дилерийн үйл ажиллагаа болно.

“Ард Лайф” ХХК нь 2012 оны 03-р сарын 10-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 02 тоот тогтоолоор Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр анх үүсгэн байгуулагдсан. 2012 оны 04 сарын 13-ны өдөр Улсын Бүртгэлийн Албанд шинэчлэн бүртгүүлж 5588731 регистрийн дугаар бүхий 9011339130 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан.

“Ард Лайф” ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь гадаад худалдаа боловч тайлант хугацаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын тухай мэдээллийг Тэмдэглэл 46-т оруулсан. Холбогдох хэсэгт тусгайлан зааснаас бусад тохиолдолд Тэмдэглэл 46-т заасан бодлогуудыг хэрэглэсээр ирсэн.

Группийн үйл ажиллагааны болон тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг (“Төгрөг”) болно. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (“НББОУСХ”)-ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) болон НББОУСХ-ны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна.

СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг.

Хэмжилтийн Үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн:

- Санхүүгийн хэрэглүүр – бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх
- Санхүүгийн хэрэглүүр – борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө
- Санхүүгийн хэрэглүүр – Зээл ба авлага
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- Болзошгүй төлбөр

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

3. ТАЙЛАН НЭГТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС 10 *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-ийн дагуу нэгтгэгч компани болох “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болон түүний охин компаниудын бэлтгэгдсэн санхүүгийн тайлангуудыг нэгтгэн илэрхийлж байгаа бөгөөд нэгтгэлд хамрагдаж буй нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь ижил хугацаагаар тасалбар болж, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн нэг бодлого баримтлан бэлтгэгддэг.

Групп нь санхүүжигч талд хяналттай бол тухайн санхүүжигч талыг охин компани гэж ангилна. Дараах хяналтын гурван шалгуурыг бүгдийг нь хангасан тохиолдолд компанийг санхүүжигч талд хяналттай гэж үзнэ. Үүнд:

- Санхүүжигч талыг зохицуулах эрх мэдэлтэй;
- Санхүүжигч талын үйл ажиллагаанаас төрөл бүрийн өгөөж хүртдэг; бөгөөд
- Өөрт буй эрх мэдлээ тухайн өгөөжид нөлөөлөхүйц байдлаар ашиглах чадвартай.

Эдгээр хяналтын шалгуур өөрчлөгдсөн байж болзошгүй гэж үзэхэд хүргэсэн баримт, нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналтыг дахин үнэлнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн болон түүний охин компаниудын (“Групп”) үр дүнг нэг аж ахуйн нэгж мэтээр тайлагнадаг. Иймд группийн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ компани болон охин компанийн хооронд хийгдсэн ажил гүйлгээнүүд болон үлдэгдлийг бүрэн цэвэрлэдэг.

Санхүүгийн байдлын тайланд нэгдэгчийн тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр зэргийг нь олж авсан өдрөөрх бодит үнэ цэнээр тусгасан. Худалдан авсан буюу олж эзэмшсэн компаниудын үйл ажиллагааны үр дүнг тухайн хяналт бий болсон өдрөөс эхлэн нэгтгэсэн Ашиг, алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг бөгөөд хяналтгүй болсон өдрөөс эхлэн нэгтгэлээс хасна.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ, толгой болон охин компаниудын санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого болон зардлын ижил төстэй зүйл тус бүрийн дүнг мөр мөрөөр нь нэмж нэгтгэсэн.

Дараах зүйлсийг нэгтгэлээс цэвэрлэж тайлагнасан. Үүнд:

- a) Бүлэг доторх компаниудын хоорондын
 - Хөрөнгө, өр төлбөрийн данснуудын үлдэгдэл;
 - Орлого болон зардлын дүн;
- b) Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнэ болон өмчийн дүн.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

(a) Өөдрөг төсөөлөл

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг групп нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа явуулна гэсэн өөдрөг төсөөллийн үндсэн дээр бэлтгэсэн.

(b) Үнэ цэнийн бууралт

Хөрөнгө эсвэл хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээсээ давбал үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Эргэн төлөгдөх дүнг тогтоохдоо удирдлага нь хөрөнгө тус бүрийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн үрсгалыг тооцоолж, эдгээр мөнгөн үрсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд тохирох хүүг сонгож ашигладаг. Ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн үрсгалыг хэмжихдээ удирдлага нь ирээдүйн үйл ажиллагааны үр дүнгийн талаар төсөөлөл гаргадаг. Энэ төсөөлөл нь ирээдүйд болох тодорхой нөхцөл байдал болон үйл явдлуудтай холбоотой болно. Бодит үр дүн нь өөр байж болох ба энэ нь дараагийн санхүүгийн жилд багтаж компанийн хөрөнгүүдэд хийгдэх томоохон залруулгуудын шалтгаан байж болно.

Ихэнх тохиолдолд тохирох хөнгөлөлтийн түвшнийг тодорхойлохдоо зах зээлийн эрсдэл болон хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлийн тохируулгыг хийдэг.

(c) Элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Группийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бүс хөрөнгө болон өмч, барилга, тоног төхөөрөмж гэх мэт элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Тэмдэглэл 46 k болон l-д биет бүс хөрөнгө, өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааны талаар дэлгэрэнгүй тусгасан.

(d) Бараа материал

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо тооцоолол хийх үеийн хамгийн найдвартай бэлэн байгаа нотолгоог авч үздэг. Группийн бизнес нь технологийн өөрчлөлттэй нягт уялдаатай бол борлуулалтын үнэ нь хурдан өөрчлөгдөхөд хүргэнэ.

Бараа материалын дансны үнийн ирээдүйд гарах өөрчлөлт нь зах зээлийн сегмент бүр дэх үнийн өөрчлөлтөөс шалтгаална.

(e) Хяналтын үнэлгээ

Групп нь санхүүжигч компани дахь хөрөнгө оруулалтаа үнэлэхдээ СТОУС 10 *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-аар шаардсаны дагуу эрх мэдэл, хувьсах өгөөж хүртэх боломж, эрх мэдэл ба үр өгөөжийн уялдааг авч үздэг бөгөөд хяналтыг тайлант жил бүрийн эцэст үнэлдэг. Хяналт нь санхүүжигч дахь оролцооноос хамааран өөрчлөгдөх магадлалтай.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ (үргэлжлэл)

(f) Бодит үнэ цэнийн хэмжилт

Группийн санхүүгийн тайланд хэд хэдэн хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, тодруулахыг шаарддаг.

Группийн санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэмжээгээр хэрэглэдэг. Бодит үнэ цэнийн хэмжилтэд хэрэглэгддэг өгөгдлийг ажиглагдахуйц байдлаар нь гурван түвшинд ангилдаг ('бодит үнэ цэнийн шатлал'):

Түвшин 1: Идэвхтэй зах зээл дэх ижил төстэй зүйлсийн жишиг үнэ (тохируулга хийгдээгүй)

Түвшин 2: Түвшин 1-ээс бусад ажиглагдахуйц шууд эсвэл шууд бус өгөгдөл

Түвшин 3: Үл ажиглагдахуйц өгөгдөл (зах зээлийн бус мэдээлэл).

Өгөгдсөн зүйлсийн бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөө үзүүлэх хэрэглэгдсэн өгөгдлийн хамгийн бага түвшинд үндэслэн зүйлсийг дээрх түвшинд ангилдаг.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Групп нь үйл ажиллагаагаараа дамжуулж дараах эрсдэлүүдэд өртөх магадлалтай:

- Зээлийн эрсдэл
- Бодит үнэ цэнийн болон хүүгийн түвшний эрсдэл
 - Гадаад валютын эрсдэл
 - Бусад зах зээлийн эрсдэл
- Төлбөрийн чадварын эрсдэл

Бусад бүх бизнесийн нэгэн адил Групп нь санхүүгийн хэрэглүүр хэрэглэснээс үүдэлтэй эрсдэлд өртдөг. Энэ тэмдэглэлд Группийн эрсдэлийн удирдлагын бодлого, энэхүү эрсдэлийг зохицуулах процесс ба түүнийг хэмжих аргуудыг тайлбарлана. Эдгээр эрсдэлтэй холбоотой нэмэлт тоон мэдээллийг санхүүгийн тайланд зохих ёсоор толилуулсан.

Энэхүү тэмдэглэлд өөрөөр дурдаагүй л бол Группийн санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлд өртөмхий байдал, эдгээр эрсдэлийг зохицуулахад чиглэсэн зорилт, бодлого ба процесс болон түүнийг хэмжихэд хэрэглэгдсэн бодлогод өмнөх жилүүдтэй харьцуулахад ямар нэгэн биет өөрчлөлт ороогүй гэж үзнэ.

i) Санхүүгийн үндсэн хэрэглүүрүүд

Группэд санхүүгийн эрсдэл үүсэж болох группийн ашиглаж буй санхүүгийн үндсэн хэрэглүүрүүдэд дараах хэрэглүүрүүдийг хамруулна.Үүнд:

- Худалдааны ба бусад авлага;
- Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө;
- Урт болон богино хугацаат зээлийн авлага;
- Дуусгавар хугацаа хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө;
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө;
- Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө
- Арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө
- Худалдааны ба бусад өглөг
- Богино болон урт хугацаат зээл
- Урт хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг
- Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг
- Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөгийн богино хугацаанд төлөгдөх хэсэг

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

ii) Санхүүгийн хэрэглүүрийн төрөл

а. Санхүүгийн хөрөнгө

	Бодит үнэ цэнэ, ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө		Зээл болон авлага		Борлуулах зорилготой санхүүгийн хөрөнгө	
	2016 мян.төг	2015 мян.төг	2016 мян.төг	2015 мян.төг	2016 мян.төг	2015 мян.төг
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө	-	-	1,442,040	140,000	-	-
Зээлийн авлага	-	-	9,417,384	5,793,301	-	-
Худалдааны болон бусад авлага	-	-	2,396,200	9,181,053	-	-
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	-	-	-	-	1,230,413	1,115,913
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө	-	-	-	-	327,133	2,000
Арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө	57,654	4,872	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	-	3,610,491	7,485,551	-	-
	57,654	4,872	16,866,115	22,599,905	1,557,546	1,117,913

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

ii) Санхүүгийн хэрэглүүрийн төрөл (үргэлжлэл)

b. Санхүүгийн өр төлбөр

	Бодит үнэ цэнэ, ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр		Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр	
	2016 мян.төг	2015 мян.төг	2016 мян.төг	2015 мян.төг
Худалдааны болон бусад өглөг	-	-	(3,624,092)	(7,583,049)
Богино- хугацаат зээл	-	-	(1,154,501)	(486,564)
Урт-хугацаат зээл	-	-	(200,000)	(429,343)
Урт-хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	-	-	(110,127)	-
Урт-хугацаат зээлийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	-	-	(20,406)	(11,976)
Санхүүгийн түрээсийн богино хугацаат төлөгдөх хэсэг	-	-	(31,326)	-
	-	-	(5,140,452)	(8,510,932)

iii) Бодит үнэ цэнээр хэмжигдэхгүй санхүүгийн хэрэглүүрүүд

Бодит үнэ цэнээр илэрхийлэгдээгүй санхүүгийн хэрэглүүр нь мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө, худалдааны ба бусад авлага, худалдааны ба бусад өглөг, зээл, түрээсийн өглөг зэргийг агуулна.

Нэг жилээс доош богино хугацааны шинж чанартай санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүд нь санхүүгийн тайланд бодит үнэ цэнэтэй ойролцоогоор тусгагдсан байдаг.

iv) Бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хэрэглүүр

2016 оны 12 сарын 31-рх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шатлалыг доор харууллаа.

	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
Арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө	57,654	-	-	57,654
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө	-	327,133	-	327,133
	57,654	327,133	-	384,787

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

2015 оны 12 сарын 31-рх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шатлалыг доор харууллаа.

	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
Санхүүгийн хөрөнгө				
Арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө	4,872	-	-	4,872
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө	-	2,000	-	2,000
	4,872	2,000	-	6,872

Тайлант жилийн турш бодит үнэ цэнийн тооцоололд ашигласан өгөгдлийн шатлал хооронд ямар нэгэн шилжүүлэг хийгдээгүй.

Ерөнхий Зорилго, Бодлого ба Процесс

Группийн удирдлага нь Группийн эрсдэлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ түүнийг тодорхойлж бэлтгэх үүрэгтэй байдаг.

Удирдлагын гол зорилго нь Группийн өрсөлдөх чадвар, уян хатан байдалд хэт нөлөөлөхгүйгээр эрсдэлийг аль болох бууруулах бодлого тогтоох явдал юм.

а) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь үйлчлүүлэгч эсвэл санхүүгийн хэрэглүүр дэх бизнесийн түнш нь гэрээгээр заасан өр төлбөр төлөх үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Группэд санхүүгийн гарз учруулах эрсдэл юм. Зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн томоохон дүн нь Тэмдэглэл 22 ба 29 *Зээлийн авлага* болон Тэмдэглэл 30, *Худалдааны болон бусад авлага*-ын үлдэгдэлд төвлөрч байгаа хэдий ч Групп найдваргүй авлагын болон зээлийн эрсдэлтийн нөөц байгуулах, хөрөнгө барьцаалах зэргээр энэхүү эрсдэлийг удирддаг.

б) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь Групп хүүтэй, худалдагдах, гадаад валютаарх санхүүгийн хэрэглүүрийн хэрэглээнээс үүсдэг. Энэ нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ нь хүүгийн хувь (хүүгийн түвшний эрсдэл), гадаад валютын ханш (валютын эрсдэл) эсвэл зах зээлийн бусад хүчин зүйлс (бусад үнийн эрсдэл)-ийн улмаас хэлбэлзэх эрсдэл юм.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

i) Бодит үнэ цэнийн болон хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм.

Группийн хүү бүхий санхүүгийн хөрөнгө нь Зээлийн авлага бөгөөд жилийн 12% -ийн хүүгийн түвшинтэй. Санхүүгийн өр төлбөрийн гол хэсгийг бүрдүүлэгч өглөг нь жилийн 6.5%-17%-ийн хүүгийн түвшинтэй учраас хүүгийн түвшний эрсдэлд өртөх нь дунд зэрэг.

Хүү бүхий авлага, өглөгийн дүнг доорх хүснэгтэд харуулав.

	Жилийн хүүгийн түвшин	2016 оны 12 сарын 31 мян.төг	2015 оны 12 сарын 31 мян.төг
Зээлийн авлага	12%	9,417,384	5,793,301
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	12%-22%	1,649,304	897,757
Өрийн бичиг	14.4-17%	1,442,040	140,000
Банкны зээл	6.50%	200,000	429,343
Санхүүгийн түрээсийн өглөг	12.00%	110,127	-

ii) Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл

Группийн хэмжээнд Монгол улсын мөнгөн тэмдэгт (төгрөг)-ээс өөр валютаар хийж буй хөрөнгө оруулалт буюу бусдад олгосон зээл, санхүүжилт буюу банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, худалдан авалт болон борлуулалтад гадаад валютын эрсдэл учирч болно. Эрсдэлд өртөж болох валют нь АНУ-ын ам.доллар байна. Гадаад валютын ханшийн хэт хэлбэлзэл нь тус Группийн санхүүгийн байдал, мөнгөн урсгалд нөлөөлөх магадлалтай.

Тайлант жилүүдийн явцад ашиглагдаж байсан төгрөгтэй харьцах ханшийг дор үзүүлэв.

Валют	Дундаж ханш		Хаалтын ханш	
	2016 он	2015 он	12/31/2016	12/31/2015
Ам.доллар	2144.85	1,970.31	2489.53	1,995.98
Юань	322.59	313.53	357.96	307.54
Иен	19.78	16.29	21.19	16.58

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

ii) Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл (үргэлжлэл)

Группийн санхүүгийн хөрөнгийн дүнг валютын төрлөөр харуулав.

	Төгрөгөөр илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрүүд		Ам.доллараар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрүүд		Бусад валютаар илэрхийлэгдсэн хэрэглүүрүүд		Нийт	
	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Санхүүгийн хөрөнгө								
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө	1,442,040	140,000	-	-	-	-	1,442,040	140,000
Зээлийн авлага	5,945,779	3,382,564	3,471,605	2,410,737	-	-	9,417,384	5,793,301
Худалдааны болон бусад авлага	2,297,668	8,426,986	98,532	748,599	-	5,468	2,396,200	9,181,053
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	1,230,413	1,115,913	-	-	-	-	1,230,413	1,115,913
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө	327,133	2,000	-	-	-	-	327,133	2,000
Арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө	30,306	-	27,348	-	-	-	57,654	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,319,982	4,546,307	290,235	2,939,244	274	-	3,610,491	7,485,551
Нийт санхүүгийн хөрөнгө	14,593,321	17,613,770	3,887,720	6,098,580	274	5,468	18,481,315	23,717,818

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

5. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР - ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

ii) Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл (үргэлжлэл)

Группийн санхүүгийн өр төлбөрийн дүнг валютын төрлөөр харуулав.

	Төгрөгөөр илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрүүд		Ам.доллараар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрүүд		Бусад валютаар илэрхийлэгдсэн хэрэглүүрүүд		Нийт	
	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Санхүүгийн өр төлбөр	-	-	-	-	-	-	-	-
Худалдааны болон бусад өглөг	(3,114,900)	(7,412,233)	(505,283)	(167,542)	(3,909)	(3,274)	(3,624,092)	(7,583,049)
Богино хугацаат зээл	(1,154,501)	(486,564)	-	-	-	-	(1,154,501)	(486,564)
Урт хугацаат зээл	(200,000)	(429,343)	-	-	-	-	(200,000)	(429,343)
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	-	-	(110,127)	-	-	-	(110,127)	-
- (ж) ААН-ийн нэрийн өмнөөс эсвэл холбоотой талын нэрийн өмнөөс ААН өр төлбөрийг барагдуулах

Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд холбоотой талуудын ажил гүйлгээний нөлөөллийг тусад нь харуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд ижил үзүүлэлтүүдийг нийтэд нь тодруулж болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

j. Ажилчдын тэтгэмж

i) Түр хугацааны ажилчдын тэтгэмж

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн групп хуулийн дагуу шагнал, урамшуулал олгох хариуцлага хүлээх болон шагнал, урамшууллын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат шагнал, урамшууллын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

k. Өмч, барилга, тоног төхөөрөмж

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг групп зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх хүлээн зөвшөөрсний дараа үеэс анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь хэмжинэ. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн нэгтгэсэн зүйл болгон бүртгэдэг.

Дараа үеийн зардал

Сольж тавьсан эд анги, хэсэг нь ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх бөгөөд өртгийг нь найдвартай хэмжих боломжтой үед Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг тайланд хөрөнгийн дансны үнэд нэмж хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Томоохон урсгал засвар үйлчилгээнүүд

Тухайн эд ангитай холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг компанид авчрах болон өртгийг нь найдвартай хэмжих боломжтой байх үед дараа үеийн зардлыг хөрөнгийн дансны үнэд нэмж эсвэл нэгтгэсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

к. Өмч, барилга, тоног төхөөрөмж (үргэлжлэл)

Тухайн тайлант хугацаанд гарсан бусад бүх засвар үйлчилгээний зардлуудыг тухайн зардал гарсан тайлант хугацаанд нь Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Олз болон гарз

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлсийг худалдан борлуулснаас үүсэх олз буюу гарз нь дансны үнийг борлуулсан үнэтэй харьцуулж тодорхойлох бөгөөд Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз, гарзаар бүртгэгдэнэ.

Дуусаагүй барилга

Дуусаагүй барилга нь хараахан дуусгаагүй буюу суурилуулаагүй байгаа барилгын ажлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Барилгын ажлын дууссан хэсэг нь компанийн үйл ажиллагаанд ашиглагдах бөгөөд ашиглалтад орсон хэсгээс бусад дуусаагүй барилгад барилгын болон суурилуулалтын ажлын явцад элэгдэл байгуулдаггүй.

Элэгдэл

Тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлэх өртгөөс шулуун шугамын аргаар элэгдэл тооцох бөгөөд элэгдлийг тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Элэгдүүлэх өртөг нь тухайн хөрөнгийн анхны өртгөөс ашиглалтын хугацааны эцэст буцаан борлуулах боломжит өртгийг хассан дүн байна. Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

▪ Барилга, байгууламж	40 жил
▪ Машин механизм, техник тоног төхөөрөмж	10 жил
▪ Тээврийн хэрэгсэл	10 жил
▪ Компьютер түүний эд анги, программ хангамж	3 жил
▪ Конторын тавилга, эд хогшил	10 жил
▪ Бусад үндсэн хөрөнгө	10 жил

л. Биет бус хөрөнгө

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд эдийн засгийн ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна.

м. Гүүдвил

Бизнесийн нэгдлээр худалдан авсан бусад хөрөнгөөс үүссэн эдийн засгийн ирээдүйн өгөөжийг илэрхийлдэг, тусад нь тодорхойлж, тусгайлан хүлээн зөвшөөрөх боломжгүй хөрөнгө юм. Худалдан авалтын өдрөөрх нэгдэгчийн тодорхойлогдох хөрөнгө болон тооцоолсон өр төлбөрт зориулан нэгтгэгчээс төлсөн илүү мөнгөний хэмжээгээр анх хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд хүлээн зөвшөөрөлтийн дараа үеүдэд хуримтлагдсан хорогдол болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь үнэлж хэмжинэ.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

п. Хараат компани

Компани санхүүжигчийн санхүү болон үйл ажиллагааных нь бодлогод хяналт тавьдаггүй хэдий ч шийдвэр гаргалтад нь оролцох эрх мэдэлтэй үед Хараат Компаниуд гэнэ. Хараат компаниудыг Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайланд анх өртгөөр нь бүртгэнэ. Дараа үеүдэд хараат компаниудыг өмчийн аргыг хэрэглэн бүртгэнэ. Өмчийн арга хэрэглэн бүртгэхдээ худалдан авалтын дараах Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Компанид ногдох хувийг Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд тусгана (алдагдал хүлээх үүрэг хүлээгээгүй л бол алдагдал нь компанийн хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалтаас хэтрэхгүй).

Компани болон түүний хараат компаниудын хооронд хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн ашиг, алдагдлыг хараат компани дах холбоогүй талын хөрөнгө оруулагчийн хувь оролцооны хүрээнд л хүлээн зөвшөөрнө. Эдгээр ажил гүйлгээнээс үүссэн хараат компанийн ашиг, алдагдлын хөрөнгө оруулагчид ногдох хувийг хараат компанийн дансны үнэтэй цэвэрлэнэ.

Худалдан авсан тодорхойлогдож болох хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөрийн компанид ногдох хувийн бодит үнэ цэнээс хараат компаниудад төлсөн урамшуулал хэтэрч байгаа бол тухайн зөрүүг капиталжуулж, хараат компанийн дансны үнэд тусгана. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралт үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа тохиолдолд санхүүгийн бус бусад хөрөнгийн нэгэн адил тухайн хөрөнгө оруулалтын дансны үнэд үнийн бууралтын сорил хийж гүйцэтгэнэ.

о. Хамтарсан хэлцэл

Компани болон нэг ба түүнээс их этгээдүүдийн хооронд байгуулсан хэлцлээр холбогдох үйл ажиллагаанд хамтарсан хяналттай гэдгийг баталсан тохиолдолд Компанийг хамтарсан хэлцлийн этгээд гэж үзнэ. Хамтарсан хяналтыг охин компани дах хяналттай ижил зарчмаар үнэлнэ.

Компани хамтарсан хэлцэл дэх хувь оролцоог дараах байдлаар ангилдаг. Үүнд:

- (a) *Хамтарсан үйлдвэр*: Компани хамтарсан хэлцлийн цэвэр хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй;
- (b) *Хамтарсан үйл ажиллагаа*: Компани хамтарсан хэлцлийн хөрөнгийг захиран зарцуулах болон өр төлбөрийг төлж барагдуулах эрх, үүрэгтэй.

Компани хамтарсан хэлэлцээр дэх хувь оролцооны ангиллыг үнэлэхдээ дараах зүйлсийг авч үздэг:

- Хамтарсан хэлцлийн бүтэц
- Нэгтгэсэн аж ахуйн нэгж хэлбэрээр байгуулагдсан хамтарсан хэлцлийн хуулийн бүтэц
- Хамтарсан хэлцлийн гэрээний нөхцөл
- Бусад баримт, нөхцөл байдал (бусад гэрээт хэлцэл гэх мэт).

Компани хамтарсан үйлдвэр дэх хувьд оролцоог Хараат Компаниудад оруулсан хөрөнгө оруулалттай ижил аргаар бүртгэнэ (өмчийн арга).

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

о. Хамтарсан хэлцэл (үргэлжлэл)

Хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтад төлсөн аливаа урамшуулал нь худалдан авсан тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөрийн компанид ногдох хувийн бодит үнэ цэнээс давсан тохиолдолд тухайн зөрүүг капиталжуулж хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнэд тусгана. Хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралт үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа бол бусад санхүүгийн бүс хөрөнгөтэй ижил аргаар хөрөнгө оруулалтын дансны үнийн бууралтыг шалгана.

Гэрээгээр хүлээсэн эрх үүргийн дагуу компани өөрт ногдох хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх замаар хамтарсан үйл ажиллагаан дах хувь оролцоог бүртгэдэг.

р. Урьдчилж төлсөн зардал, тооцоо

Бэлтгэн нийлүүлэгчдэд урьдчилан төлсөн ирээдүйд зардлаар эсвэл хөрөнгөөр хаагдах мөнгөн бүс хөрөнгийг өртгөөр нь хуримтлуулан бүртгэж Санхүүгийн Байдлын Тайлангийн эргэлтийн хөрөнгө хэсэгт тайлагнана.

қ. Бараа материал

Борлуулах зориулалтай бараа материалыг эхэлж өртгөөр нь үнэлж бүртгэх бөгөөд дараа үед өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар тусгана. Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн нөхцөлд авч ирэх хүртэлх зардлыг оруулна. Цэвэр боломжит үнэ цэнэ нь тогтоогдсон борлуулах үнээс зарж борлуулахтай холбоотой зардлуудыг хассан дүнгээр тодорхойлогдоно. Хуучирсан, илүүдэл нөөцтэй, болон удаан гүйлгээтэй бараа материалуудыг олж тогтоож, цэвэр боломжит үнэ хүртэл нь бууруулж бүртгэдэг.

Бараа материалын өртөг нь бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахад гаргасан бүхий л зардлыг агуулдаг ба дундаж өртгийн аргыг ашиглан зарлагаддаг.

г. Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд дансны болон бусад авлагуудыг өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд хүлээн зөвшөөрөлтийн дараа үеүдэд авлагын үнэгүйдлийг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ. Худалдааны болон бусад авлагын үнэгүйдлийн хасагдуулга нь компани авлагын анх үүссэн үеийн нөхцөлийн дагуу бүрэн хэмжээгээр цуглуулж чадахгүй байж магадгүй гэсэн бодит нотолгоонд суурилан тогтоодог. Хасагдуулгын дүн нь дансны үнэ ба таамагласан мөнгөн урсгалыг ижил төрлийн зээл борлуулалтын зах зээлийн хүүгийн түвшнээр хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээр тогтоосон эргэн нөхөгдөх дүнгийн хоорондын зөрүү юм. Хасагдуулгын дүнг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютаарх авлагын дансны үнийг тайлангийн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж тодорхойлно. Тайлант хугацааны дундуур гадаад валютаар төлсөн авлагыг төгрөгт шилжүүлж ханшийн зөрүүгийн бодит олз ба гарзыг тооцно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (ҮРГЭЛЖЛЭЛ)

s. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгүүд нь бэлэн мөнгө болон бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө, тусгай зориулалт бүхий мөнгөн сан, мөнгөтэй адилтгах бусад зүйлс, 3 сар хүртэл хугацаатай хадгаламжаас бүрдэнэ.

t. Санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн хөрөнгөө доор дурдсан байдлаар ангилдаг.

(i) Бодит Үнэ Цэнэ нь Ашиг, Алдагдлаар Хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд зөвхөн ашигтай үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Нэгтгэсэн Дэлгэрэнгүй Орлогын Тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана.

(ii) Зээл ба Авлага

Зээл ба авлага гэсэн ангилалд багтах санхүүгийн хөрөнгө нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй үүсмэл бус санхүүгийн хөрөнгө байдаг. Ийм төрлийн санхүүгийн хөрөнгө нь ихэвчлэн харилцагчдад өгсөн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөөцөөр (дансны авлага) дамжиж үүсэх бөгөөд мөн бусад төрлийн гэрээгээр хүлээсэн мөнгөөрх хөрөнгөөс бүрддэг байна. Зээл ба авлагыг бодит үнэ цэнэ дээр нь худалдан авалттай шууд хамааралтай ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрөх ба дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр бүртгэнэ.

Компани авлагаа бүгдийг нь цуглуулж чадахгүй гэсэн бодит нотолгоотой (харилцагч санхүүгийн хүндрэлд орох, дампуурах, урт хугацаагаар хойшлуулах) бол үнэ цэнийн бууралтын нөөц үүсгэх ба тухайн нөөцийн үнийн дүнг үнэ цэнийн бууралт үүсгэж буй авлагын дансны цэвэр үнэ болон ирээдүйн таамагласан мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр тооцно. Цэвэр дүнгээр тайлагнагддаг дансны авлагын үнэ цэнийн бууралтыг тусад нь нөөцийн данс үүсгэж, гарзыг нь Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайлангийн удирдлагын зардалд тусгана. Дансны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнэ цэнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Компанийн зээл ба авлага нь Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан дах худалдааны ба бусад авлага, холбоотой талаас авах авлага болон мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөс бүрддэг.

Кассын үлдэгдэл, банкны хадгаламж, гурван сар ба түүнээс доош дуусах хугацаатай бусад богино хугацаат хөрвөгч хөрөнгө оруулалт болон банкны овердарфт (мөнгөн гүйлгээний тайлангийн зорилготой)-аас мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө бүрдэнэ. Банкны овердрафтыг Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлангийн богино хугацаат өр төлбөрийн зээл ба зээллэгт тусгана.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

t. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

(iii) Борлуулахад Бэлэн

Өмнөх ангиллуудад багтаагүй үүсмэл бус хөрөнгийг борлуулахад бэлэн гэсэн ангилалд оруулах ба үүнд ихэвчлэн охин компани, хараат компани, хамтарсан хяналттай аж ахуйн нэгжүүдийн шалгуурыг хангаагүй байгууллагуудад компанийн оруулсан хөрөнгө оруулалт багтдаг. Эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Валютын ханшийн хэлбэлзэл болон үр ашигт хүүгийн түвшин хэрэглэн тооцсон хүүгээс үүссэн өөрчлөлтөөс бусад бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод тусгаж, борлуулахад бэлэн нөөцөд хүримтлуулна. Гадаад валютаар илэрхийлэгдсэн бөгөөд хүүг нь үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцдог хөрөнгө оруулалтын ханшийн зөрүүг ашиг, алдагдалд тусгана.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ их хэмжээгээр эсвэл удаан хугацааны турш буурсан бол (үнэ цэнийн бууралт үүссэн гэсэн бодит нотолгоо болно) тухайн үнэ цэнийн бууралтын нийт дүнг өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн үнийн дүнгийн хамт ашиг, алдагдалд тусгана.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн худалдан авалт, борлуулалтыг төлбөр төлөгдөх өдрөөр хүлээн зөвшөөрнө. Арилжааны өдөр ба төлбөр хийгдэх өдрийн хооронд гарсан үнэ цэнийн бууралтын өөрчлөлтийг борлуулахад бэлэн нөөцөд бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө борлуулах үед борлуулахад бэлэн нөөцөд хүримтлагдсан олз, гарзыг ашиг, алдагдлаар дахин ангилна.

(iv) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших

Тогтмол тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтсон хугацаанд дуусгавар болох дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд аж ахуйн нэгж үүнийг дуусгавар өдөр хүртэл нь эзэмших зорилго, чадвартай гэж өөдрөгөөр төсөөлж байгаа хөрөнгө багтана. Анх өртгөөр нь хэмжиж хүлээн зөвшөөрөх бөгөөд дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжиж тайлагнана.

u. Санхүүгийн өр Төлбөр

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

(i) Бодит Үнэ Цэнэ нь Ашиг, Алдагдлаар Хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай үүсмэл хэрэглүүр багтана (ашигтай үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн Хөрөнгө” хэсгээс хар). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Нэгтгэсэн Ашиг, Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайланд тусгана. Компанид арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

(ii) Хорогдуулсан Өртгөөр Хэмжигдэх

Компанийн хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт худалдааны болон бусад өр төлбөр, банкны зээл, хувьцаанд хөрвөх зээлийн өглөг зэрэг хамаарна. Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр үнэлж, хэмжинэ.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

v. Нийлмэл санхүүгийн хэрэглүүр

Компани санхүүгийн өр төлбөрийг үүсгэж байдаг ба эзэмшигч тал тухайн хэрэглүүрийг компанийн өмчийн хэрэглүүрээр хөрвүүлэх сонголтыг олгож байдаг санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг Санхүүгийн Байдлын Тайланд тус тусад нь хүлээн зөвшөөрч толилуулна.

Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн дансны анхны үнийг өмчийн ба өрийн хэсгүүдэд хуваарилах үед тухайн хэрэглүүрийн бодит үнэ цэнээс өрийн хэсгээр салган тодорхойлсон дүнг бүгдийг нь хассаны дараа үлдэх дүнгээр өмчийн хэрэглүүр тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл энгийн хувьцаанд уг хэрэглүүрийг хөрвүүлэх сонголтыг харуулсан өмчийн хэрэглүүрийн дансны үнийг хэрэглүүрийг бүхэлд нь авч үзэж, үнэлсэн нийлмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнээс санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг хасаж тодорхойлно.

w. Хувьцаат капитал

Хувьцаат капитал нь компанийн гаргасан хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр хэмжигддэг.

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүдийг өмчөөр ангилж бүртгэнэ.

Бүх өр төлбөрийг хассаны дараа хөрөнгөөс үлдэх хувь оролцоог нотлох аливаа хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэнэ.

x. Ноогдол ашиг

Ногдол ашиг нь хувьцаа эзэмшигчдийн компанид оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийн татан авалт юм. Ногдол ашиг олгох эсэх болон нэгж хувьцаанд хэдэн төгрөгийн ногдол ашиг олгохыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр тогтоох бөгөөд түүний зарласан тайлант хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

y. Худалдааны болон бусад өглөг

Худалдааны болон бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

z. Нөөц сан

Даатгалын тухай хууль болон даатгалын багц дүрмийн дагуу Компани дараах нөөцийн сангуудыг даатгалын хэлбэр тус бүрээр байгуулдаг. Үүнд:

- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц
- Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан
- Нэхэмжилсэн хохирлын нөөц сан
- Учирч болзошгүй хохирлын нөөц сан

Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг даатгагчийн хүлээн авсан даатгалын хураамжийг гэрээний үлдэх хугацаанд ногдуулан байгуулна. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг 8-тын аргаар тооцдог. Даатгалын гэрээг нэг жилээс өөр хугацаатай байгуулсан тохиолдолд орлогод тооцоогүй хураамжийг хувь тэнцүүлэн тооцдог.

Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан

Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц санг даатгалын тохиолдол нь тайлант улирлаас өмнөх үед учирсан бөгөөд тайлант улиралд нэхэмжилж болзошгүй нөхөн төлбөрийг барагдуулахад зориулан байгуулдаг. Энэхүү нөөцийн санг өмнөх хугацааны даатгалын нөхөн төлбөрийн бодит мэдээлэлд үндэслэн актуар тооцооллоор тооцож, орлогод тооцсон хураамжаас улирал бүр байгуулдаг. Актуар тооцооллын дараах аргуудаар тооцоолж, арифметик дунджаас даатгалын хэлбэр тус бүрийн хувьд 30-100 хувь өсгөх замаар байгуулдаг. Үүнд:

- Гинжин шатлалын
- Дундаж зардлын
- Төлөвлөлтийн

Нэхэмжилсэн хохирлын нөөц сан

Нэхэмжилсэн хохирлын нөөцийн санг тухайн тайлант хугацаанд даатгуулагчаас ирүүлсэн нэхэмжлэлийн дүнгээр, даатгалын тохиолдол гарсан хугацаанаас хамааран учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан эсвэл орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг хорогдуулж байгуулна.

Учирч болзошгүй хохирлын нөөц сан

Учирч болзошгүй хохирлын нөөц сан нь тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөр бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц сан юм. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд учирч болзошгүй хохирлын нөөц санг дараах томьёогоор байгуулдаг.

$$[(\text{ОТХ} - \text{аас олгосон НТ} + \text{байгуулсан УБНХНС}) / \text{ОТХ}] \times 100\% < X \text{ үед}$$

$$\text{УБНХНС} = [X - (\text{ОТХ} - \text{аас олгосон НТ} + \text{байгуулсан УБНХНС} / \text{ОТХ}) \times 100\%] \times \text{ОТХ}$$

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

46. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

з. Хувьцаанд суурилсан төлбөр

Өмчөөр хаагдах хувьцааны опционыг ажилчдад олгосон бол опцион олгосон өдрөөрх бодит үнэ цэнээр нь Нэгтгэсэн Дэлгэрэнгүй Орлогын Тайланд баталгаажих хугацааных нь турш тусгана. Баталгаажна гэж үзэж буй өмчийн хэрэгслийн тоо хэмжээг тохируулах байдлаар баталгаажих зах зээлийн бус нөхцөлийг тусгах бөгөөд ингэснээр ирээдүйд баталгаажих опционы тоо хэмжээнд үндэслэн хуримтлагдсан үнийн дүнг баталгаажих хугацаанд нь хүлээн зөвшөөрдөг. Үл баталгаажих нөхцөл болон баталгаажих зах зээлийн нөхцөлийг олгосон опционы бодит үнэ цэнээр үржүүлнэ. Бусад бүх баталгаажих нөхцөлийг хангасан л бол баталгаажих зах зээлийн нөхцлийг хангасан эсэхээс үл хамаарч Нэгтгэсэн Дэлгэрэнгүй Орлогын Тайланд тусгана. Баталгаажих зах зээлийн нөхцөлийг хангаж чадахгүй байх эсвэл үл баталгаажих нөхцөлийг хангаагүй тохиолдолд хуримтлагдсан зардлыг тохируулахгүй.

Опцион баталгаажихаас өмнө түүний хугацаа, нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд опционы бодит үнэ цэнийн өсөлтийг тухайн өөрчлөлтийн өмнөхөн эсвэл дараа нь шууд хэмжиж, үлдсэн баталгаажих хугацаанд нь Нэгтгэсэн Дэлгэрэнгүй Орлогын Тайланд тусгана.

Ажилчдаас бусад хүмүүст өмчийн хэрэгсэл олгосон тохиолдолд хүлээн авсан бараа үйлчилгээний бодит үнэ цэнээр нь Нэгтгэсэн Дэлгэрэнгүй Орлогын Тайланд тусгана.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

47. ХАРААХАН МӨРДӨГДӨЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

а) 2016 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх шинэ стандартууд, түүний тайлбарууд ба нэмэлт өөрчлөлтүүд

ОУ стандартын зохицуулах хорооноос гарсан СТОУС-н дагуу 2016 оны 12 сарын 31 нээрх жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх байгууллагуудад хамаатай анх удаа хэрэгжиж буй шинэ СТОУС болон өмнөх СТОУС-д орсон нэмэлт өөрчлөлт, сайжруулалтууд:

СТОУС	2016 оны 12 сарын 31-нээрх СТОУС шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
СТОУС 10, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, СТОУС 12, Бусад аж ахуйн нэгж дэх хувь оролцооны тодруулга, НББОУС 28, Хараат ба хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт-д орсон өөрчлөлт	(i) Аж ахуйн нэгжийн эцсийн (эсвэл дундын) толгой компани нь СТОУС 10-ын дагуу (бүх охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтаа нэгтгэлгүйгээр бодит үнэ цэнээр бүртгэдэг хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийг оруулан) бэлтгэхдээ дундын толгой компани нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахаас чөлөөлөгдөх боломжтой болохыг энэхүү нэмэлт өөрчлөлт нь тайлбарлана. (ii) Хөрөнгө оруулалтын толгой аж ахуйн нэгж нь - охин компани нь өөрөө хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж биш - охин компанийн гол зорилго нь хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулах үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ үзүүлэх байх үед л охин компанийг нэгтгэнэ. (iii) Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр хэмжиж санхүүгийн тайлангаа бэлтгэдэг хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж нь СТОУС 12-аар шаардсан тодруулгуудыг хөрөнгө оруулалтын нэгжийн хувьд толилуулах шаардлагатай болохыг уг өөрчлөлтөөр тайлбарласан. (iv) Өөрөө хөрөнгө оруулалтын нэгж биш боловч хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт хувь оролцоотой Аж ахуйн нэгж нь өмчийн арга ашиглаж байгаа бол хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр дэх өөрсдийн оролцоог бүртгэхдээ тус хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрийн ашигласан бодит үнэ цэнийн хэмжүүрийг ашиглаж болно.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
СТОУС 11, Хамтын Хэлэлцээр-т оруулсан нэмэлт өөрчлөлт	Нэмэлт өөрчлөлтийн дагуу, нэгж байгууллага нь СТОУС 3-т тодорхойлогдсон үйл ажиллагаа эрхэлдэг хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо худалдан авч байгаа тохиолдолд СТОУС 3-т заасан бүх зарчмыг мөрдөх шаардлагатай. Мөн уг нэмэлт өөрчлөлт нь шинээр 2 жишээ нэмэн оруулсан болно.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

47. ХАРААХАН МӨРДӨГДӨЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД (үргэлжлэл)

а) 2016 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх шинэ стандартууд, түүний тайлбарууд ба нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)

СТОУС	2016 оны 12 сарын 31-нээрх СТОУС шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
СТОУС 14 Хойшлогдсон зохицуулалтын данснууд	СТОУС 14-н цар хүрээ бага, зөвхөн дараах байгууллагуудыг хамарна: - СТОУС-г анх удаа хэрэгжүүлж буй; - Үнийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг; - Холбогдох хөрөнгө болон өр төлбөрөө өөрсдийн улсын НХЗНББЗ-ын дагуу хүлээн зөвшөөрдөг. СТОУС 14 – н хүрээнд багтсан аж ахуйн нэгжүүд нь хойшлогдсон зохицуулалтын данснууд гэж томъёолох үнийн зохицуулалтаас үүдэн бий болсон хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, үнэлэх, хорогдлыг хэмжихдээ өөрсдийн өмнөх ашиглаж байсан дотоодын GAAP-н зарчимд үндэслэн сонголтоор хийх боломжтой. Аливаа хойшлогдсон зохицуулалтын дансны үлдэгдэл болон тэдгээрийн ашиг алдагдалд үзүүлэх нөлөө нь үндсэн санхүүгийн тайлан дах бусад зүйлсээс тусдаа тайлагнагдана.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга – д орсон нэмэлт өөрчлөлт	<i>Тодруулгын санаачилга</i> НББОУС 1-д дараах зүйлстэй холбоотой нэмэлт өөрчлөлт орсон болно: - Материаллаг - Үндсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд - Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга - НББ бодлого Түүнчлэн, СТОУС-н Тайлбарын Хороонд ирүүлсэн хүсэлтийн дагуу НББОУС 1-т дараах өөрчлөлтийг оруулав: - Өмчийн аргаар бүртгэгдэх хөрөнгө оруулалтууд	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
НББОУС 16 Өмч, Барилга, Тоног төхөөрөмж болон НББОУС 38 Биет бус хөрөнгө – д орсон нэмэлт өөрчлөлт	<i>Элэгдэл болон хорогдлыг тооцох хүлээн зөвшөөрсөн аргын талаарх тодруулга</i> НББОУС 16 – д өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлсийн элэгдлийг орлогод суурилсан аргыг ашиглахыг хориглох өөрчлөлт оруулсан. НББОУС 38 - д хорогдуулгыг орлогод суурилж тооцох нь зохимжгүй гэсэн маргаантай таамаглалуудыг шийдвэрлэх үүднээс өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү үзэл суртлыг дараах нөхцөлийн аль нэгээр няцаасан: - Тухайн биет бус хөрөнгө нь орлогод суурилж илэрхийлэгдсэн; эсвэл - Орлого болон биет бус хөрөнгийн эдийн засгийн өгөөжийн зарцуулалт нь хоорондоо өндөр хамааралтай.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

47. ХАРААХАН МӨРДӨГДӨЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД (үргэлжлэл)

а) 2016 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх шинэ стандартууд, түүний тайлбарууд ба нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)

СТОУС	2016 оны 12 сарын 31-нээрх СТОУС шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
НББОУС 16 Өмч, Барилга, Тоног төхөөрөмж болон НББОУС 41 Хөдөө аж ахуй – д орсон нэмэлт өөрчлөлт	<i>Хөдөө аж ахуй: Үр жимс өгдөг ургамал</i> Энэхүү өөрчлөлт нь НББОУС 16–ын цар хүрээнд үр жимс өгдөг ургамлыг багтааж, цар хүрээг өргөсгөх зориулалттай хийгдсэн бөгөөд үүнд Үр жимс өгдөг ургамал гэдэг нь дараах шинж чанарыг агуулсан амьд ургамал юм хэмээн тодорхойлсон: - Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд хэрэглэгддэг; - Үр жимсээ 1 мөчлөгөөс их хугацаанд өгөх хүлээлт үүсгэсэн; ба - Борлуулагдах магадлал бараг байхгүй. Дээрх өөрчлөлтийн дагуу, үр жимс өгдөг ургамлыг НББОУС 16 – д заасны дагуу дараах загварын аль нэгээр бүртгэнэ: - Өртгийн загвар, эсвэл - Дахин үнэлгээний загвар Үр жимс өгдөг ургамал нь цаашдаа НББОУС 41-т багтахгүй. Харин, үр жимс өгдөг ургамлаас гарсан бүтээгдэхүүн нь НББОУС 41-т багтсан хэвээр байна. Мөн, анх удаа хэрэгжүүлэхэд шилжилтийн зааварчилгаа хэлбэрээр дараах өөрчлөлтийг багтаасан болно: - Таамагласан өртгийн чөлөөлөлт - Тодруулга	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
НББОУС 27 Тусдаа Санхүүгийн тайлан – д орсон нэмэлт өөрчлөлт	<i>Тусдаа Санхүүгийн тайланд өмчийн аргыг хэрэглэх</i> Энэхүү өөрчлөлт нь аж ахуйн нэгж байгууллага нь тусдаа санхүүгийн тайлан бэлтгэхдээ, өөрсдийн охин компани, хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтаа өмчийн аргаар бүртгэж болох сонголтыг нэмж танилцуулсан. Тухайн сонгосон НББ-н зарчим нь хөрөнгө оруулалт бүрд ижил хэрэгжих шаардлагатай. Үүнээс үүдэлтэйгээр, НББОУС 28 Хараат компани дах хөрөнгө оруулалт – д СТОУС 10 Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан – н хэсэгчлэн борлуулалттай холбоотой үүсэж болох зөрчлөөс зайлсхийх үүднээс өөрчлөлт оруулсан.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
СТОУС 5 Борлуулах Зорилгоор Эзэмшиж байгаа Эргэлтийн Бүс Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа (СТОУС 2012-2014 циклд хийх жил бүрийн сайжруулалтын дагуу хийсэн өөрчлөлт)	<i>Борлуулалтын аргад орсон өөрчлөлт</i> Хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгийг Борлуулах зорилготой эргэлтийн бүс хөрөнгөөс эзэмшигчид хуваарилсан гэсэн ангилал руу эсвэл урвуугаар дахин ангилах нь анх борлуулах зорилго агуулсан төлөвлөгөөний үргэлжлэл хэсэг болно.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

47. ХАРААХАН МӨРДӨГДӨЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД (үргэлжлэл)

а) 2016 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх шинэ стандартууд, түүний тайлбарууд ба нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)

СТОУС	2016 оны 12 сарын 31-нээрх СТОУС шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга (СТОУС 2012-2014 цикл хийх жил бүрийн сайжруулалтын дагуу хийсэн өөрчлөлт)	СТОУС 7 – д орсон нэмэлт өөрчлөлт нь гэрээт ажлын үйлчилгээ болон 2011 оны 12 сард мөн СТОУС 7-д оруулсан өөрчлөлтийг завсар үеийн санхүүгийн тайланд хэрэгжүүлэх гэсэн 2 сэдвийг хамарсан болно. (i) Гэрээт ажлын үйлчилгээ НББОУСЗ нь тухайн байгууллага шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой үргэлжилсэн оролцоо байх тохиолдолд авах арга хэмжээг тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь НББОУС 8-н дагуу буцаан мөрдөх горимын дагуу мөн хэрэгжүүлэхийг шаардах боловч тус байгууллага энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлж эхэлсэн тайлант жилээс өмнөх өмнөх үеүдэд хэрэгжүүлэгдсэн байх шаардлагагүй. (ii) Завсар үеийн хураангуйлсан тайланд буцаалтыг хэрэгжүүлэх СТОУС 7-н энэхүү өөрчлөлтийн дагуу 2011 оны 12 сард хийгдсэн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн буцаалтын өөрчлөлтийг бүх завсар үет хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзэв.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
НББОУС 19 Ажилчдын тэтгэмж (СТОУС 2012-2014 цикл хийх жил бүрийн сайжруулалтын дагуу хийсэн өөрчлөлт)	Хөнгөлөлтийн хувь - бүс нутгийн зах зээлийн асуудал НББОУС 19 – д ажилчдын тэтгэмжийн хөнгөлөлтийн хувийг тодорхойлоход ашиглаж буй өндөр чанарын компанийн бондын нэрлэсэн үнэ нь тухайн тэтгэмж ажилтанд олгогдох валюттай ижил валютаар илэрхийлэгдэх шаардлагатай гэсэн нэмэлт өөрчлөлт орсон.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
НББОУС 34 Завсар Үеийн Санхүүгийн Тайлан–д орсон нэмэлт өөрчлөлт	Завсар үеийн тайлангийн аль нэг хэсгийн мэдээллийн тодруулга НББОУС 34 нь завсар үеийн тайлангийн аль нэг хэсэгт тайлагнагдаагүй тодруулгуудыг тайлангийн тайлбар хэсэгт тусгахыг шаарддаг (эхэн үеийн менежментийн тайлан гэх мэт). Хэрэв тухайн тодруулга нь завсар үеийн тайлангийн аль нэг хэсэг (менежментийн зөвлөгөө эсвэл байгууллагын эрсдэлийн тайлан)-д тайлагнагдсан бол тайлангийн тайлбар хэсэгт багтсан зүйлтэй нь харилцан холболт хийх ёстой.	2016 оны 1 сарын 1-н болон 1-нээс дараах тайлант жилүүдэд зайлшгүй мөрдөнө. Түүнээс өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

47. ХАРААХАН МӨРДӨГДӨЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД (үргэлжлэл)

*b) 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх шинэ стандартууд, түүний тайлбарууд
ба нэмэлт өөрчлөлтүүд*

ОУ стандартын зохицуулах хорооноос гарсан СТОУС-н дагуу 2017 оны 12 сарын 31 нээрх жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэх байгууллагуудад хамаатай анх удаа хэрэгжиж буй шинэ СТОУС болон өмнөх СТОУС-д орсон нэмэлт өөрчлөлт, сайжруулалтууд:

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
СТОУС 9 (2014) 2014 оны 07 дугаар сард гаргасан	СТОУС 9, Санхүүгийн Хэрэглүүр нь НББОУС 39, Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт-ийг орлож гарсан стандарт юм. СТОУС 9 нь санхүүгийн хөрөнгийн ангилал ба хэмжилт, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт, санхүүгийн өр төлбөрийн ангилал ба хэмжилт, өрийн эрсдэлийн шаардлагыг хугацаанаас өмнө мөрдөх, санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт, хэйджийн бүртгэл зэрэг асуудлуудыг тайлбарлана. Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд: • Хорогдуулсан өртөг • Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр • Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр (residual category); • Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр (өмчийн хэрэглүүрийн зарим хөрөнгө оруулалтад ашиглах боломжтой). Санхүүгийн өр төлбөрийг • Хорогдуулсан өртөг • Ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр;	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
СТОУС 15 2014 оны 05 дугаар сард гаргасан	СТОУС 15, Харилцагчтай байгуулсан гэрээний Орлого нь НББОУС 18, Орлого, НББОУС 11, Барилгын гэрээ болон холбогдох тайлбарууд (СТСБХ 13, харилцагчийн Лоялти Хөтөлбөр, СТСБХ 15 Үл хөдлөх хөрөнгийн Барилгын гэрээ, СТСБХ 18, Харилцагчаас хөрөнгө шилжүүлэх, ТБХ 31 Орлого – Сурталчилгааны Үйлчилгээний Бартер ажил гүйлгээ) орлож гаргаж ирсэн. Энэхүү стандартын гол зорилго нь компани нь хэрэглэгчид амласан бараа, үйлчилгээнийхээ шилжүүлсэн хэсэгт ногдох, тэдгээр бараа үйлчилгээг хүргэснийхээ хариуд авах эрхтэй болсон дүнгээр орлого хүлээн зөвшөөрөх юм. Энэхүү стандартаар орлогыг хүлээн зөвшөөрөх 5 үе шатыг хэрэглэхийг шаарддаг. 1. Гэрээг тодорхойлох 2. Гүйцэтгэлийн үүргүүдийг тодорхойлох 3. Ажил гүйлгээний үнийг тодорхойлох 4. Ажил гүйлгээний үнийг гүйцэтгэлийн үүрэг тус бүрт хуваарилах 5. Гүйцэтгэлийн үүрэг биелэгдэх үед орлого хүлээн зөвшөөрөх	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

47. ХАРААХАН МӨРДӨГДӨЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД (үргэлжлэл)

b) 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх шинэ стандартууд, түүний тайлбарууд
ба нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
СТОУС 15 Нэмэлт өөрчлөлт 2016 оны 04 дугаар сард гаргасан	2015 оны 09 сард Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан СТОУС 15 –ийн хэрэгжиж эхлэх хугацааг нэг жилээр хойшлуулан 2018 оны 01 сарын 01 болгосон. 2016 оны 04 сард Олон Улсын Стандартын Зөвлөл дараах тодотголуудыг гаргасан: -Гүйцэтгэлийн үүргийг тодорхойлох -Ерөнхий болон агентын бодлогын ялгаа -Лицензийн гэрээ хэлцэл -Тогтмол бүс хөнгөлөлт	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
СТОУС 16 2016 оны 01 дугаар сард гаргасан	СТОУС 16 нь НББОУС 17, Түрээс, СТСБХ 4, түрээс агуулсан хэлцэл эсэхийг тодорхойлох, ТБХ 15, Үйл ажиллагааны түрээс – Урамшуулал, ТБХ 27, Түрээсийн эрх зүйн хэлбэртэй холбоотой ажил гүйлгээний мөн чанарыг үнэлэх зэрэг стандарт, тайлбаруудыг орлоно. СТОУС 16-ын гол томоохон өөрчлөлт нь үйл ажиллагааны болон санхүүгийн түрээсийн хоорондын ялгааг арилгах мөн санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн "ашиглах эрхийг" болон түрээсийн гэрээний өр төлбөрийг тусгах цор ганц загварыг тодорхойлсон.	2019 оны 01 сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. СТОУС 15 нь хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
НББОУС 7-ийн нэмэлт өөрчлөлт 7 – Нэмэлт тодруулгын санаачилга	Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжүүдийн өрийн талаарх нэмэлт өөрчлөлтүүдийг сайжруулах зорилготой. Нэмэлт тодруулгууд нь санхүүжилтийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний болон мөнгөн бүс гүйлгээний өөрчлөлтийг үнэлэх боломжийг санхүүгийн тайлан хэрэглэгчдэд олгох ёстой. Дараах тохируулгыг нэмж тодруулна. Үүнд: • Эхний үлдэгдэл • Тайлант хугацааны хөдөлгөөн: - Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний өөрчлөлт - Охин компани дахь буюу бусад бизнес дэх хувь оролцоог олж эзэмших эсвэл алдахтай холбоотой өөрчлөлт, - Бусад мөнгөн бүс солилцоо (Жишээ нь: Гадаад валютын ханшийн, санхүүгийн түрээс, бодит үнэ цэнийн өөрчлөлт); • Эцсийн үлдэгдэл.	2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
НББОУС 12 дахь нэмэлт өөрчлөлт 2016 оны 01 дугаар сард гаргасан	НББОУС 12-д орсон энэхүү өөрчлөлт нь үнэ цэнийн бууралт гараагүй өрийн хэрэгслийг бодит үнэ цэнээр хэмжихтэй холбоотой хойшлуулсан татварын хөрөнгийг бүртгэх талаар тайлбарласан. Татвар бууруулах түр зөрүү нь өрийн хэрэгслийн бодит үнэ цэнээр хэмжихтэй холбоотой бодит бүс гарзаас үүснэ.	2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

47. ХАРААХАН МӨРДӨГДӨЖ ЭХЛЭЭГҮЙ БАЙГАА ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД (үргэлжлэл)

б) 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх шинэ стандартууд, түүний тайлбарууд ба нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
НББОУС 28 дахь нэмэлт өөрчлөлт 2016 оны 12 дугаар сард гаргасан	НББОУС 28-аар хэрэв хөрөнгө оруулалт нь шууд буюу шууд бусаар хамтын хөрөнгийн байгууллага, итгэлцлийн нэгж буюу адилгах аж ахуйн нэгж эзэмшиж буй бол хараат ба хамтын үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэхээс илүү ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх бодит үнэ цэнээр хэмжихийг зөвшөөрсөн.	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
НББОУС 40 дэх нэмэлт өөрчлөлт 2016 оны 12 дугаар сард гаргасан	Энэхүү өөрчлөлт нь ашиглалтын зорилгод өөрчлөлт орох үед үл хөдлөх хөрөнгийг ХОЗҮХХ рүү эсвэл түүнээс ангилах асуудлыг тодруулсан. НББОУС 40.57-д багтсан шилжилт нь ашиглалтын зориулалтын өөрчлөлтийг дэмжих нотолгооны жишээг гаргасан.	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
СТОУС 1 СТОУС дахь нэмэлт өөрчлөлт 2016 оны 12 дугаар сард гаргасан	СТОУС 1, СТОУС-ын анх удаа хэрэгжүүлэх-д заасан богино хугацааны чөлөөлөлтөөс заримыг устгасан. Эдгээр чөлөөлөлтөөр олгогдсон жишээг дахин ашиглахааргүй болсон.	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
СТОУС 2 СТОУС 2 дахь нэмэлт өөрчлөлт 2016 оны 06 дугаар сард гаргасан	Тухайлсан зааварчилгаа тодорхой бус байх тохиолдолд тодорхой нөхцөлүүдэд хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээнүүдийн ангилал ба хэмжилтэд энэ нэмэлт тодруулга зориулагдсан.	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
СТОУС 4 дэх нэмэлт өөрчлөлт 2016 оны 09 дугаар сард гаргасан	Энэхүү өөрчлөлт нь даатгалын гэрээ гаргах гол үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжид СТОУС 9-ийг хэрэглэхийг хойшлуулахыг зөвшөөрсөн ба ашиг алдагдлаас бусад дэлгэрэнгүй орлого руу нэмэлт өөрчлөлтийг шилжүүлэх арга хандлагыг тайлбарласан.	2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.
СТОУС 10 болон НББОУС 28 дахь нэмэлт өөрчлөлт 2016 оны 09 дугаар сард гаргасан	Энэхүү өөрчлөлтөөр өмчийн арга хэрэглэн тухайн охин компани дахь бүх эсвэл зарим хувь оролцоогоо хараат компани эсвэл хамтарсан үйлдвэрт борлуулах замаар толгой компани охин компани дахь хяналтаа алдсан тохиолдолд ажил гүйлгээний нягтлан бодох бүртгэлийг тодруулсан бөгөөд СТОУС 3 Бизнесийн Нэгдэлд заасан бизнесийг бүрдүүлдэггүй.	Хэрэгжиж эхлэх хугацаа тодорхой бус хугацаагаар хойшлогдсон.
СТОУС 12 дахь нэмэлт өөрчлөлт 2016 оны 12 дугаар сард гаргасан	В-10-В16 дахь параграфд зааснаас бусад тохиолдолд СТОУС 5-ын дагуух борлуулах зорилготой, эзэмшигчдэд хуваарилах зорилготой зогсоосон үйл ажиллагаа гэж ангилах эсэхээс хамаарахгүйгээр СТОУС 12-т нэмж тодруулахаар цар хүрээнд өөрчлөлт орсон.	2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

48. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Ард Даатгал ХХК нь 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдөр №11/01/157 тоот даатгалын гэрээ байгуулсан. Даатгалын гэрээ нь 2011 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 00 цагаас 2012 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 24 цаг хүртэл хүчин төгөлдөр байхаар заасан. Уг гэрээний зүйл буюу даатгалын зүйл нь Үлэмж ХХК-ийн гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн бүтээгдэхүүн үйлчилгээний хариуцлага бөгөөд нийт үнэлгээ нь 1,250,000 мянган төгрөг, хураамж нь 6,875 мянган төгрөг байхаар заасан.

Ард даатгал ХХК болон Үлэмж ХХК-үүд нь талуудын байгуулсан даатгалын гэрээ болон Үлэмж ХХК-аас ирүүлсэн даатгалын гүйцэтгэлийн баталгаа нь тус тусдаа бие даасан бүс нэгдмэл гэрээ бөгөөд бие биеэсээ салшгүй хэсэг, харин Шангри Ла Улаанбаатар Хотел ХХК нь дээрх 2 гэрээ тус тусдаа гэрээнүүд бөгөөд даатгалын гүйцэтгэлийн баталгааны гэрээ бүс батлан даалтын гэрээ гэдэг дээр талууд маргасан.

Ард даатгал ХХК нь 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Ард даатгал ХХК болон Үлэмж ХХК-үүд нь талуудын байгуулсан даатгалын гэрээ, Шангри Ла Улаанбаатар Хотел ХХК-ийн эзэмшиж буй даатгалын баталгааг хүчин төгөлдөр бусад тооцуулахаар нэхэмжлэл гаргасан. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх хэргийг 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр хянан хэлэлцээд шүүхийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагуудыг хэрэгсэхгүй болгосон тухай 181/ШШ2016/01080 тоот шийдвэрийг гаргасан.

Компани нь Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд холбогдох асуудлаар нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүхийн зүгээс 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хянан хэлэлцэж “Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 181/ШШ2016/01080 тоот шийдвэрийг хэвээр үлдээж нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.” утга бүхий 143 тоот магадлал гаргасан.

Мөн компани нь Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхэд гомдол гаргасан. Шүүх хуралдааны 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 001/хт2017/00316 тоот тогтоолоор “Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 181/ШШ2016/01080 дугаар шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 143 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасугай” шийдвэр гаргасан байна.

49. ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс тодорхой зарим зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

50. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

- Ард Кредит ББСБ ХХК нь ТУЗ-ийн 2017 оны 02 сарын 22-ны өдрийн хурлын № 2017/4 тоот шийдвэрээр 200 сая төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн ба ногдол ашгийг 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр төлж дуусгасан.
- Мөн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хувь нийлүүлэгч, өөрийн ажилтан, холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад активын дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 10 хувь, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй гэсэн шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй (10-ийг давсан 2 зээлдэгч, холбоотой талд олгосон зээлийн нийлбэр 48.2%) байсан. Энэхүү үзүүлэлт нь балансын дараа холбоотой талын зээлүүд төлөгдсөнөөр багассан бөгөөд холбогдох нэг этгээдэд олгох зээлийн хэмжээг давсан нэг зээлдэгч (11 %), нийлбэр дүнгээр 25.79% болж багассан байна.
- Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь 2017 оны 03 сард 24 сарын хугацаатай 19,2 хувийн хүүтэй 2 тэрбум төгрөгийн компанийн бонд гаргасан.

51. ТАЙЛАНГИЙН ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол болон Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга агуулгын зөрүү гарах тохиолдолд Монгол хэл дээрх хувилбарыг баримтална.